

12 Aggressive behavior

Түрэмгий зан авиртай суралцагчидтай ажиллах нь

1

This module deals with working with students who display aggressive behavior

Энэхүү модуль хичээл нь

2

towards people in the school environment,

сургуулийн орчинд бусад хүмүүстэй, багш болон бусад суралцагчидтай харилцахдаа

3

both towards the teacher and other students.

түрэмгий зан авир гаргадаг хүүхдүүдтэй хэрхэн ажиллах талаар авч үзнэ.

4

The module consists of two parts.

Энэ модуль хичээл нь хоёр хэсгээс бүрдэнэ.

5

The first part deals with actions of a preventive character such as minimizing stress.

Эхний хэсэгт стресс бууруулах зэрэг түрэмгий зан авир гаргахаас сэргийлэх арга хэмжээнүүдийн тухай авч үзнэ.

6

The second part discusses concrete procedures of dealing with aggressive behaviour of a student.

Хоёр дахь хэсэгт түрэмгий зан авиртай суралцагчидтай ажиллах бодит арга хэмжээнүүдийн тухай авч үзнэ.

7

The key to effective education, and above all, effective educational activities

Үр дүнтэй сургалтын гол түлхүүр нь

8

is a good relationship between teacher and student.

багш, суралцагчид хоорондоо сайн харилцаатай байх явдал юм.

9

The positive nature of a good relationship
between teacher and student

Багш, суралцагчдын эерэг харилцаа нь

10

is demonstrated by mutual trust,
kindness and respect.

харилцан итгэлцэл,
сайхан сэтгэл, хүндлэл дээр суурилан бий болдог.

11

It is the teacher who plays the leading role
in the formation of such a relationship

Иймэрхүү харилцаа үүсгэхэд голлох үүрэг гүйцэтгэдэг багшийн хувьд

12

even if the student behaves
in an aggressive way.

суралцагч хэдий түрэмгий догшин ааш авир гаргаж байсан ч шантралгүй
ажиллах ёстой байдаг.

13

How can the teacher build
a good relationship with the pupil?

Багш сурагчидтай хэрхэн сайн харилцаатай болох вэ?

14

First of all, by looking for and finding
individual possibilities

Юуны өмнө, суралцагчийн хувийн онцлог

15

and potentialities of the student.

болон ерөнхий чадамжийг олж харах ёстой юм.

16

Also by keeping faith in the student,
in his good intentions

Мөн суралцагч хэдийн түрэмгий ааш зан гаргаж байсан ч

17

and respect the student
even if he behaves in an aggressive way.

түүний итгэл, зөв хандлагыг хадгалан хүндэтгэж байх нь чухал.

18

An important principle in
working with emotional students

Сэтгэлийн хөдөлгөн ихтэй суралцагчидтай ажиллах нэг чухал зарчим бол

19

is to be careful not to spark
the fire of their strong emotions.

тэднийг огцом сэтгэл хөдлөлд автсан үед нь улам дэвэргэхгүй байх
явдал юм.

20

Since stress is the most common reason for
strong negative emotions to surface in students,

Стресс нь суралцагчийг маш сөрөг сэтгэл хөдлөлд автуулдаг түгээмэл
шалтгаан тул

21

the teacher's first priority
is to minimize stress.

багшийн эхний ээлжинд хийх зүйл бол стрессийг бууруулах явдал юм.

22

The teacher will achieve this goal by:
not asking surprise questions,

Багш энэхүү зорилтыг хэрэгжүүлэхдээ:
гэнэтийн асуулт асуухгүй байх,

23

not forcing students to answer,

асуултанд хариулахыг хүчлэж шаардахгүй байх,

24

not comparing students with one another,

нэгийг нь бусадтай нь харьцуулахгүй байх,

25

not engaging in humiliating criticism of students,

хүүхдүүдийг доромжилсон шүүмжлэлд хамруулахгүй байх,

26

not assuming a position of superiority
toward students, and

суралцагчдаас давуу талтай байдлаа ашиглаж харьцахгүй байх,

27

not formulating vague or impossible expectations.

Тодорхой бус, боломжгүй хүлээлт үүсгэхгүй байх шаардлагатай.

28

What if, despite attempts to reduce stress,
a teacher is confronted with aggressive behaviour of a student?

Стресс бууруулах оролдлогуудыг үл харгалзан түрэмгий зан ааш гаргасаар байвал багш яах вэ?

29

Before taking any specific corrective action,

Залруулах ямар нэг үйлдэл хийхээсээ урьдаар

30

it is worthwhile for the teacher to realize that his priority is
to ensure the safety of the students and himself.

багш суралцагчийн болон өөрийн аюулгүй байдлыг хангах ёстой юм.

31

At the same time, the teacher must not break
the good relationship with the student

Үүний зэрэгцээ багш суралцагчийг хүндлэхээ больж

32

by withdrawing the respect due to the student.

бий болгосон сайн харилцаагаа таслаж болохгүй.

33

Let's now turn to the procedure to be applied
when aggressive behavior is displayed.

Одоо түрэмгий зан авир гаргаж байгаа тохиолдолд авах арга хэмжээнүүдийг авч үзье.

34

It consists of seven steps.

Энэ нь 7 алхмаас бүрдэнэ.

35

The first step is to become aware
of one's own feelings

Эхний алхам нь суралцагчийн гаргаж буй түрэмгий зан авирын хариуд гаргаж буй

36

that have arisen in response

to the student's aggressive behaviour.

өөрийн мэдрэмжийг хянах явдал юм.

37

The precondition for the correct execution of this step,

Энэ алхмыг зөв хийх урьдач нөхцөл нь

38

is to concentrate on one's own emotions
as soon as possible.

өөрийн сэтгэл хөдлөлийг аль болох түргэн хянах явдал юм.

39

Postponing the identification
of the own emotional state is unhelpful.

Нэгэнт өөрт төрсөн сэтгэл хөдлөлийг илэрхийлсний дараа хянах нь ямар
ч тус нэмэргүй.

40

Therefore, immediately after
the student's aggressive behaviour,

Иймээс суралцагч түрэмгий авир гаргасны дараа

41

try to answer honestly the question:
"what is going on inside me, what feelings am I struggling with?"

"дотор минь юу болж байна (ямар бодол, мэдрэмж төрж байна? Би ямар
мэдрэмжтэй тэмцэх ёстой билээ?" гэх асуултанд өөртөө үнэн
сэтгэлээсээ хариулахыг хичээх хэрэгтэй.

42

Step two is about preventing
the escalation of aggressive actions.

Хоёр дахь алхам бол түрэмгий үйлдэл нь хурцадмал байдалд хүрэхээс
сэргийлэх алхам юм.

43

It is imperative that the teacher rejects
the urge to revenge and use power.

Багш хүч хэрэглэх, өшөө авах, эрх мэдлээ ашиглах хүслээ заавал дарах
ёстой.

44

Although the natural reaction to aggression
seems to be aggression, stop it.

Хэдийгээр түрэмгийллийн эсрэг байгалийн хариу үйлдэл нь түрэмгийлэл
байдаг хэдий ч үүнийг зогсоох хэрэгтэй.

45

Do not allow forceful actions, such as,
"I will show you!"

"Чамд би үзүүлээд өгнө" гэх мэт хүч хэрэглэсэн өнгө аястай үйлдэл гаргаж болохгүй.

46

This is a powerful trap.
Be sure to engage your curiosity.

Энэ бол маш хүчтэй урхи бөгөөд учир зүйг нь олох ёстой гэдэгтээ өөрийгөө итгүүлэх хэрэгтэй.

47

Try to face the question:
"What is the student trying to tell me through this aggressive behavior?"

"Ингэж түрэмгий ашигснаараа энэ сурагч надад юу хэлэх гээд байна вэ?" гэсэн асуултыг өөрөөсөө асуугаад үзээрэй.

48

The teacher can move on to step three
when the danger of revenge has been overcome.

Өшөө авах хүсэлд автах аюулаас ангижирсан тохиолдолд багш гуравдугаар алхамруу шилжиж болно.

49

This involves performing an emotional flip-flop.

Энэ нь сэтгэл хөдлөлийн гэнэтийн эргэлт хийх явдал юм.

50

Although teachers already know their own feeling,
including anger, perhaps rage or helplessness,

Хэдий багш нар арга мөхөсдөн уурлах гэх мэт сэтгэл хөдлөлд автсан ч гэлээ

51

they will now treat these feelings
as if they are not theirs.

эдгээр мэдрэмжээ өөрт нь төрсөн мэдрэмж биш мэтээр үлдэн хөөх ёстой байдаг.

52

It has come to them from a student and is
information about him, not about the teacher.

Иймэрхүү мэдрэмж суралцагчаас үүдэн бий болж байгаа бөгөөд тухайн хүний мэдээлэл болохоос багшийнх биш юм.

53

00:05:03,052 --> 00:05:09,809

Taking step four is to read the information contained in the aggressive behavior of a student.

Дөрөв дэх алхам бол сурагчийн гаргасан түрэмгийн зан авирт нуугдаж буй мэдээллийг унших явдал юм.

54

00:05:10,893 --> 00:05:19,110

The anger and helplessness the teacher is experiencing is the anger and helplessness of the student.

Багшид учирч буй уур бухимдал, арга мөхөсдсөн байдал нь суралцагчийн мөн тийм байдлаас үүдэн бий болж байгаа юм.

55

00:05:20,153 --> 00:05:27,869

Because the student can't cope with these feelings, he throws them out in the form of aggressive behavior.

Учир нь сурагч өөрт нь төрж буй таагүй мэдрэмжээ хадгалж, давж гарч чадахгүй байгаа учраас түрэмгий аашлах байдлаар түүнийгээ уудлан гаргаж байдаг.

56

00:05:28,286 --> 00:05:33,791

This expression probably gives him temporary relief.

Ингэснээр түр тайтгарах боломжтой болдог байж болох юм.

57

00:05:35,001 --> 00:05:42,425

The fifth step is to develop increasing curiosity and investigation about the information in the list.

Тав дахь алхам бол сониуч занг нэмэгдүүлэх болон жагсаалтанд буй мэдээллийн тухай судалгаа хийх явдал юм.

58

00:05:42,925 --> 00:05:47,555

The teacher helps himself with questions such as:

Дараах асуултуудад багш өөртөө хариулт олох ёстой:

59

00:05:48,139 --> 00:05:50,975

What is the student talking about?

Суралцагч юуны тухай ярьж байна вэ?

60

00:05:51,309 --> 00:05:53,478

What does he need?

Түүнд юу хэрэгтэй байна вэ?

61

00:05:53,936 --> 00:05:57,857

For what purpose is he acting so aggressively?

Ямар зорилгоор сурагч ийм түрэмгий ааш гаргаад байна вэ? г.м.

62

00:05:58,358 --> 00:06:04,197

The teacher comes to a sincere preoccupation with the meaning of the student's behaviour.

Багш хүн сурагчийн зан авираар дамжуулан юу илэрхийлэх гээд байгаад чин сэтгэлээсээ санаа тавьж учрыг олохыг хичээх ёстой.

63

00:06:05,573 --> 00:06:11,913

Step six is to absolutely reject ineffective, deceptive solutions.

Зургаа дахь алхам бол үр дүнгүй, хуурамч шийдлүүдээс нэг мөр ангижрах явдал юм.

64

00:06:13,122 --> 00:06:17,668

When the teacher is curious about the meanings of a student's behavior,

Багш хүн сурагчийн зан авирын учир шалтгааныг анхаарч мэдсэн тохиолдолд

65

00:06:17,794 --> 00:06:20,588

he will not pretend that nothing happened.

түүнийг анзаараагүй дүр эсгэхгүй.

66

00:06:20,963 --> 00:06:27,095

Since not reacting is a manifestation of passivity and helplessness of the teacher,

Хэрэв асуудлыг анзаарсан мөртлөө тоохгүй байгаа бол тун идэвхигүй, арчаагүй багш гэсэн үг бөгөөд

67

00:06:27,303 --> 00:06:33,643

this attitude will most likely encourage the student to reinforce his aggressive behavior.

энэ байдал нь сурагчийн түрэмгий зан авирыг цаашид даамжирахад улам том түлхэц болж байдаг.

68

Neither will the teacher enter
into a discussion with a student

Сурагчийн сэтгэл хөдлөл гал мэт дүрэлзэх дээрээ тулсан үед

69

when his emotions have the force
of a powerful fire.

Багш түүнтэй ярилцах гэсний хэрэггүй.

70

The teacher rejects any form of violence
against the student.

Багш суралцагчид ямар ч төрлийн хүчирхийлэл учруулах ёсгүй.

71

He will refrain from physical, verbal,
as well as emotional aggression.

Багш хүн сэтгэл зүйн, үгэн, сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй түрэмгий зан гаргахыг ямагт тэвчих ёстой.

72

The teacher will not use his authority as a teacher
to intimidate a student,

Багш өөрийн эрх мэдлээ ашиглан суралцагчийг айлган сүрдүүлэх,

73

threaten him with consequences
that he cannot carry out.

суралцагчийн тэсвэрлэж чадахааргүй дарамт учруулах ёсгүй.

74

Nor will the teacher take offense at him,
demonstrating his resentment.

Багш суралцагчид гомдоллож уурлахгүйгээр түүний гаргасан үйлдэлд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлэх ёстой.

75

When the teacher concentrates attention
on himself and not on the student,

Багш суралцагчийг бус өөртөө анхаараад байвал

76

he will lose the opportunity to read the meaning of the information the student wants to convey to the teacher.

суралцагчийн багшдаа илэрхийлж хэлэх гээд байгаа зан авирын мэдээллийг тайлж унших боломжоо алдана гэсэн үг юм.

77

The final seventh step deals with constructive, and thus educationally effective, solutions.

Сүүлийн долоо дахь алхам бол конструктив алхам тул боловсролын үр дүнтэй шийдлүүдийг авч үздэг.

78

The teacher can take these successfully as long as he follows the previous six steps thoroughly.

Багш өмнөх зургаан алхамыг ягштал мөрдсөн бол энэ алхмыг ч бас амжилттай хэрэгжүүлж чадна.

79

So, first, when a student's aggression threatens others,

Нэгд, тухайн суралцагчийн түрэмгий байдал бусдад заналхийлэл болж байвал

80

the teacher should definitely take him out of the classroom and give him time to calm down.

багш түүнийг шууд ангиас гаргаж тайвшруулах ёстой.

81

His emotions will settle, he will cool down,

Ингээд нэгдүгээрт, тухайн суралцагчийн сэтгэл хөдлөл намдаж, тайвширсан үед л

82

and only then can the teacher have a respectful dialogue with the student.

багш түүнийг хүндэлсэн өнгө аясаар ярилцах хэрэгтэй юм.

83

Second, the teacher can try to turn anger into distress by using the following examples:

Хоёрдугаарт, багш дараах жишээнүүдийг ашиглан суралцагчийн уур уцаарыг намдааж болно:

84

"I can see that you are having a hard time for some reason.

"Би чамайг зарим шалтгааны улмаас хэцүү үетэй нүүр тулж буйг ойлгож байна.

85

I'd be happy to talk to you about it, but right now it's important that you let me and others enjoy the lesson."

Энэ талаар чамтай дуртайяа ярилцмаар байна, гэхдээ одоо чи надад болон бусаддаа хичээлээ хийх боломжийг олгох нь чухал байна".

86

The teacher can also set a time for a "one on one" conversation,

Түүнчлэн багш "нэгийн эсрэг нэг" яриа өрнүүлэх цаг төлөвлөж

87

in which he expresses his concern for the student.

энэ үеэрээ сурагчид санаа тавьж байгаагаа харуулж болно.

88

It is important that the teacher sets clear rules for behavior and a consequence for not following them.

Тэгэхдээ багш зан байдал, биеэ авч явах тухай яв цав дүрэм журам гаргаж, тэдгээрийг мөрдөхгүй тохиолдолд учирч болох үр дагавруудыг тайлбарлах нь чухал.

89

Finally, the teacher should reward any behavior he considers desirable and indicate beneficial change.

Эцэст нь багш зүй зохистой зөв зан авирыг сайшааж, эерэг өөрчлөлтүүдийг хэлж өгч байх хэрэгтэй.

90

And don't forget: appreciate any attempt to make an effort and show good intentions.

Мөн сурагчийн хүчин зүтгэл гаргаж, сайн хандлагаа харуулах гэсэн аливаа оролдлогыг үнэлж байхаа мартаж болохгүй.